

РОБЕРТ Х. Н. ХО-гийн ГЭР БҮЛИЙН САН
БУДДЫН ШАШИН СУДЛАЛЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН УРАЛДААН
2021-22

**Хэрэгжүүлэгч: Америкийн Мэдлэгт Нийгэмлэгүүдийн
Зөвлөл**

Дараах уралдаанд оролцох хугацаа нь 2021 оны 11-р сарын 15-нд Нью-Йоркийн цагаар 21.00 цагт дуусна:

- Буддын Шашин Судлалаар Эрдмийн Зэрэг Горилсон Бүтээлийн Тэтгэлэг
- Буддын Шашин Судлалын Чиглэлээр Анхлан Ажиллах Тэтгэлэг
- Буддын Шашин Судлалын Орчуулгын Тэтгэлэг

Дараах уралдаанд оролцох хугацаа нь 2022 оны 1-р сарын 11-нд Нью-Йоркийн цагаар 21.00 цагт дуусна:

- Буддын Шашин Судлалын Профессорын Тэтгэлэг
- Буддын Шашны Олон Нийтийн Эрдэмтэд

Азийн их дээд сургуулиуд болон сүм хийдийн эрдэмтдийг өргөдөл гаргахыг онцгойлон уриалж байна.

Америкийн Мэдлэгт Нийгэмлэгүүдийн Зөвлөл (ACLS) нь [Роберт Х.Н. Хо-гийн Гэр Бүлийн Сангийн](#) өгөөмөр санхүүжилтээр Буддын шашин судлалын чиглэлээр судалгаа, зааварчлагааны үйл ажиллагааг дэмжих санаачлагыг 9 дэх жилдээ зарлаж байна. Энэхүү сантай хамтран ACLS нь нийгэм болон эрдэм шинжилгээнд Буддын сэтгэлгээний ойлголт, тайлбарыг өргөжүүлэх, [Буддын шашин судлалын](#) олон улсын сүлжээг бэхжүүлэх, мөн эдгээр судлал дахь шинэлэг урсгалуудыг тодотгох ажлыг дэмжих тэтгэлэг, тэтгэлгийн уралдаан тэмцээнийг зохион байгуулдаг.

ACLS-ийн хэрэгжүүлж буй Роберт Х.Н. Хо-гийн Гэр Бүлийн Сангийн Буддын Шашин Судлалын Хөтөлбөр нь эрдмийн ажлыг хөгжүүлэх үнэт зүйлсийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох оролцоо, тэгш эрх, олон талт байдлыг эрхэмлэдэг. Тэтгэлэг, дэмжлэгт хамрагдагсад нь өөр өөр гарал үүсэл, соёл болон аль нэг талаараа өвөрмөц төлөөлөл байх нь энэхүү хөтөлбөрийн эн тэргүүний зорилго юм. Буддын шашин судлалд бид иргэний харьяалал, байгууллагын харьяалал, хэл, сэдэв, Буддын шашны уламжлал болон судалгааны байршлын тэнцвэртэй байдлыг эрэлхийлдэг.

Хөтөлбөрийн талаар ерөнхий мэдээлэл авахыг хүсвэл:

<https://www.acls.org/Programs/The-Robert-H-N-Ho-Family-Foundation-Program-in-Buddhist-Studies>

Тэтгэлгийн талаар мэдээлэл авахыг хүсвэл:

<https://www.acls.org/Competitions-and-Deadlines/The-Robert-H-N-Ho-Family-Foundation-Program-in-Buddhist-Studies>

Түгээмэл асуудаг асуултуудыг эндээс уншина уу:

<https://www.acls.org/FAQ/Robert-H-N-Ho-Family-Foundation-Program-in-Buddhist-Studies>